

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН

*/11 сар/*

Чойр 2018 он

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН

2018-11-14


WEB [/govisumber@nso.mn/](http://govisumber@nso.mn/), Face book /Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс/ хаягаар хэлтсийн танилцуулга, инфографик зэрэг бүтээгдэхүүнүүдийг цаг тухайд нь байршуулан хэрэглэгчдэд сурталчилж байна. Аймгийн WEB хуудсанд холбогдсон учир [govisumber@gov.mn](http://govisumber@gov.mn) хаягаар мэдээлэлтэй танилцах боломжтой.

- 2018 оны 10 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж аймгийн болон хэлтсийн вэб хуудсанд байршуулав.
- 2018 оны 10 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулгаар хэвлэлийн бага хурлын материал болон инфографик бэлтгэн хэлтсийн вэб болон face book хуудсанд байршуулав.
- Статистикийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн ахмадын хороо болон Шивээговь сумын ахмадын хороотой хамтран ажиллах гэрээ байгууллаа. Аймгийн ахмадын хороотой хамтарч “Статистик 11 11” өдөрлөгийг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгт 30 гаруй ахмад хамрагдсан бөгөөд давхардсан тоогоор 70 гаруй гарын авлага материал тараасан байна.
- Өдөрлөгийн үеэр “Статистик-өврийн дэвтэр”-ээ сурталчлав.
- ӨНЭЗС болон АХС-нд хамрагдсан өрхүүдэд хэлтсийн үйл ажиллагааг сурталчилж 20 орчим гарын авлага тараасан.
- Аймгийн номын санд сурталчилгааны булан нээж, тухай бүрд нь шинэ материалаар хангаж байна.



**Мэдээлэл тархаалтын байдал:**

- 2018 оны 10 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж хэвлэмэл байдлаар 45 хэрэглэгчид тараалаа.
- Цахимаар давхардсан тоогоор 200 гаруй хэрэглэгчид танилцуулга болон инфографик хүргүүлэв.
- Статистикийн ойн өдрийг угтсан арга хэмжээний хүрээнд аймгийн ахмадуудад 70 гаруй нугалбар тараасан байна.
- Хэрэглэгчийн бүртгэлээр 80 үзүүлэлтийг 21 хэрэглэгчид тархаалаа.
- Face book /Говьсүмбэр аймгийн Статистикийн хэлтэс/ [WEB](https://www.facebook.com/govisumber@nso.mn/) хаягаар [/govisumber@nso.mn/](mailto:govisumber@nso.mn) хэлтсийн танилцуулга, инфографик, хэвлэлийн бага хурлын материалыг цаг тухайд нь байршуулан хэрэглэгчдэд түгээж байна.



1212.mn мэдээллийн санг сурталчилсан байдал:

- 1212.mn мэдээллийн санг сурталчилж “Сонирхолтой статистик” буланг хэрхэн ашиглах талаар 30 гаруй иргэнд заавар зөвлөгөө өглөө.



Хууль сурталчилсан байдал:

2. Ойн арга хэмжээний хүрээнд хэлтсийн ажилтнуудын мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Төрийн албаны тухай” хуулийн шинэчилсэн найруулгаар дотоод сургалт зохион байгууллаа.



3. Мөн энэхүү хуулийн талаар аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ярилцлага мэтгэлцээн зохион байгуулав.



Мэдээлэл бэлтгэсэн: Ахлах мэргэжилтэн

Я.Отгонбаяр